

“Монгол орны төвийн бүс дэх сүү, мах үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд малын тэжээл бэлтгэл, хадгалалт тэжээллэгийг сайжруулах” төсөлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл	
1	Төслийн нэр		“Монгол орны төвийн бүс дэх сүү, мах үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд малын тэжээл бэлтгэл, хадгалалт тэжээллэгийг сайжруулах” төсөл	
2	Санхүүжүүлэгч байгууллага		НҮБ-ын ХХААБ	
4	Төсөл хэрэгжүүлж буй хугацаа		2007 оны 11 сар-2009 оны 12 сарын 31	
5	Төслийн зорилго		Төвийн бүс дэх ЭМАА-н фермерүүдийн тэжээлийн чанар, хэмжээг нэмэгдүүлэх	
6	Төслийн зорилтууд		<ol style="list-style-type: none"> Дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн малын тэжээллэгийг сайжруулж, тэжээлийн хадгалалт, үйлдвэрлэлийн боломжийг сайжруулах. Эрдэм шинжилгээний туршилт сорилт тавьснаар тэжээл үйлдвэрлэх жижиг, дунд загвар аж ахуйн нэгжийг бий болгох. Тэжээлийн ургамлын шинэ сортыг усалгаатай болон усалгаагүй нөхцөлд тариалж, үнэлэлт, дүгнэлт өгөн, тохиромжтой үрийг сонгон авч үрийг нь үржүүлэх, тэжээлийн ургамлын үр үржүүлэх аж ахуйн нэгжтэй болох. 	
7	Төслийн хамрах хүрээ болон үр шим хүртэгсэд		Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон сум, Булган аймгийн Хангал, Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн хушаат, Сайхан, Цагааннуур сум, Төв аймгийн Баянчандмань, Батсүмбэр, Жаргалант сүмбэр сумд	
8	Зардал	Төсөв/нийт шаардагдах зардал/	397,0 мян.ам.доллар	
		Гүйцэтгэл (тухайн жилд)	397,0 мян.ам доллар	
	Үүнд:	Зардлын нэр	Үнийн дүн /мян.ам.доллар/	
		<ol style="list-style-type: none"> Үндэсний зөвлөхүүдийн цалин ОУ-ын зөвлөхийн цалинд гадаад, дотоодын томилолт сургалт, семинар гэрээгээр гүйцэтгэх ажилд гадаадад туршлага судлах т/төх худалдан авах тэжээл, эрдэс, уурагт тэжээлд машины засвар үйлчилгээ <p align="center">нийт</p>	<p align="center">55,4</p> <p align="center">63,1</p> <p align="center">17,1</p> <p align="center">38,5</p> <p align="center">18,3</p> <p align="center">15,0</p> <p align="center">137,8</p> <p align="center">57,8</p> <p align="center">1,9</p> <p align="center">397,0</p>	
Санхүүгийн талаар:		Хүснэгтээс харахад: ОУ-ын болон дотоодын зөвлөхүүдэд олгосон цалин нийт зардлын 30%-ийг, техник тоног төхөөрөмж худалдан авсан зардал 34 %, тэжээл, эрдэс уурагт тэжээл худалдан авсан зардал 14.6% тус тус эзэлж байна.		
9	Төслийн хэрэгжилт		2009 оны хэрэгжилт- 75%	
	2008 онд:		Төслийн хүрээнд 5 дугаар сард тэжээлийн ургамлын үрийг дотоодоос худалдан авч 3 аймгийн 8 сум тус бүрээс нэг загвар аж ахуйн нэгжүүдийг сонгон авч, тус бүр 2 га-д тариалах, 8 тэжээлийн ургамлын 1.6 тн 2.2 сая төгрөгийн үрийг хуваарилан олгож түүнийг тариалах, тэжээл бэлтгэх, хадгалах аргачлалыг зааж, мал тэжээх технологийн сургалтууд зохион байгуулсан.	

		<p>Бэлчээрийн маллагаатай манай орны нөхцөлд мал нь намар өвсний сөл тасарснаас эхлээд зуны ногоо ургах хүртэл эрдэс витамин, уургийн дутагдалд ордог бөгөөд үүнээс шалтгаалан малын ашиг шим нь буурах, өвчинд өртөмтгий болох зэрэг сөрөг талтай. Үүнийг малчид, фермерүүдэд ойлгуулах зорилгоор МААЭШХ-нд үйлдвэрлэсэн 1750 кг эрдсийн нэмэгдэл долооц, Англи улсаас импортолсон эрдэс витамин нэмэгдэл тэжээлээр мал тэжээх туршилтыг 5 аймгийн 24 аж ахуйн нэгж фермерийн аж ахуйд туршсаны үр дүнд малчид, фермерүүдэд малын тэжээлийг бэлтгэх, түүний чанарыг алдагдуулахгүй хадгалах, малыг хэрэгцээт уураг витаминаар хангаснаар малын ашиг шим, тарга хүч буурахгүй өвөл хаврын улирлыг давж болохыг ойлгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-82,0</p>
	<p style="text-align: center;">2009 онд</p>	<p>Тус онд хавар тэжээлийн нэг наст ургамлын үрийг худалдан авч, загвар аж ахуйн нэгжүүдэд 2 га, шинээр тэжээлийн ургамал тариалж байгаа аж ахуйн нэгжүүдэд 1 га-ийн үрийг хуваарилан олгож, тариалах арга технологийн үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Үр тариа, буурцагт, олон наст тэжээлийн ургамлын үрийн шинэ сортыг БНХАУ-ын Бээжин хотын Үр үржүүлгийн хүрээлэн (101 удмын үр тарианы сорт) болон Шинэ Зеланд улсаас (55 удмын овьёос, 24 удмын үр тариа, 6 төрлийн олон наст, 6 төрлийн буурцагтан, 3 төрлийн навчит байцаа, 6 төрлийн үндэс үртэн нийт 100 сорт) импортлон УГТСЭШХ, ХААИС-ийн “Нарт” судалгааны төвтэй гэрээ байгуулан сорилт судалгааг хийж, дүгнэлт гаргасан. Үүнээс: Манай орны нөхцөлд хамгийн сайн дасан зохицон ургах, тэжээлийн шимт чанар сайтай, өндөр ургац өгч байгаа нэг наст ба буурцагт ургамлын үрийг цааш үржүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, тухайн үрийг нэмж импортлохоор гэрээ хэлцэл хийжээ. Олон наст ургамлын эхний жилийн ургацын байдал сайн бөгөөд үүний өвөлжилт, хүйтэнд тэсвэртэй байдлын дүгнэлтийг дараа жил тооцож гаргах юм байна.</p> <p>Намрын ургац хураалт болж, төсөлд хамрагдсан малчны бүлэг, фермерүүдэд тэжээлийн ургамал хураах, даршлах техник дутагдалтай байсан</p> <p>учраас жижиг гараар хэрчигч даршны техникийг 5 фермерт худалдан авч өгөн тариалсан ургамлаа даршилж хадгалах боломжийг олгосон. Түүнчлэн мочевин, чихрийн бурамт долооцыг мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээр үйлдвэрлүүлэх зорилгоор тэжээл холигч зэргийг БНХАУ-аас нийлүүлсэн.</p> <p>Тэжээлийн ургамал тариалсан хүрээлэн нь тэжээлийн ургамлын дээж авч хатаах зориулалтын зуух байхгүй, үр тариагаа цайруулах, цэвэрлэх техник тоног төхөөрөмж байхгүйгээс хураалт болон судалгааны ажилд хүндрэлтэй байсан учраас тоног төхөөрөмжийг БНХАУ-аас нийлүүлсэн.</p> <p>Алтан тариа ХХК-ийн тэжээлийн үйлдвэрээр 3 тн уургийн нэмэгдэл тэжээлийн захиалга өгч хийлгэсэн бөгөөд, тус компаниас 5 тн мочевин, чихрийн бурамт долооцын түүхий эдийг худалдан авч МААЭШХ-ийн тэжээлийн цехэд блок үйлдвэрлүүлэхээр өгчээ. Эдгээр тэжээлээр ондоо багтан сонгож авсан аж ахуйн нэгжүүд дээр туршилт судалгааны ажлыг энэ онд багтан сонгож авсан нэгжүүд дээр туршилт судалгааны ажлыг хийх юм байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-83,5</p>

	<p>Үр дүн:</p>	<p>Төсөлд хамрагдсан малчид, фермерүүд тэжээлийн ургамлаа өөрсдөө, тариалах арга техникийг эзэмшин, түүний шимт чанар эдийн засгийн ач холбогдолыг ойлгож тариалж сурсан.</p> <p>Өнгөрсөн хугацаанд царгас, согоовор зэрэг олон наст, эрдэнэ шиш, судан өвс, хөх тариа, овёос, наранцэцэг гэх мэт нэг наст тэжээлийн ургамлыг тариалах, тэжээл бэлтгэж, түүнийгээ чанарыг нь алдагдуулахгүй хадгалах арга технологийг эзэмшсэн. Чанар сайтай тэжээл бэлтгэж, хадгалах зориулалтаар Даршны техник, гар аргаар дарш хийдэг жижиг хэрчигч зэргийг нийлүүлснээр тариалсан тэжээлийн ургамлын чанарыг алдагдуулахгүй тэжээл бэлтгэх боломж бүрдсэн.</p> <p>Шинэ Зеланд, Хятадын таримал ургамлын үр үржүүлгийн хүрээлэнгээс нэг, олон наст болон буурцагт ургамлын тэжээлийн ургамлын үр импортлон сорилт судалгаа тавьсанаар тэжээлийн ургамлын төрлийг нэмэгдүүлж тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх боломжтой юм. Мөн манай орны хувьд чанар сайтай байгалийн хадлан бэлтгэх үе нь 7 сарын сүүлээс 8 сарын эх хүртэл байдаг. Иймд манай малчид фермерүүд цаг агаарын саатлаас болж өвсийг чанар сайтай ногоон үед нь хадаж чаддаггүйтэй холбогдуулан богино хугацаанд өвс бэлтгэх техникийг импортлон байгалийн хадлан болон ногоон тэжээл бэлтгэх талбайн үзүүлэх сургалтыг хийж малчид, фермерүүдэд ойлгуулсан.</p> <p>Төсөлд хамрагдсан 4 аймгийн тэжээл бэлтгэсэн байдлаас үзэхэд жилээс жилд бэлтгэсэн тэжээлийн хэмжээ, төрөл нь нэмэгдсэн нь төслийн үр дүнд эерэг хамааралтай байна.</p> <p>Түүнчлэн энэ үр дүнг цааш өргөжүүлж бусад аймаг сумын малчид фермерүүдэд хүргэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-83,5</p>
10	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<ul style="list-style-type: none"> • Судлагдсан таримлууд тэжээлийн зорилгоор тариалахад арвин ургацтай төдийгүй ихэнх нь үрийн ургац өгч байгаа нь цаашид нутагшуулах бололцоотойг харуулж байна. • Цаашид эдгээр таримлуудын анхдагч үрийн аж ахуйг зохион байгуулж тариалах агротехник, сэлгээнд зохистой оруулах судалгааг явуулах нь нутагшуулах үйл ажиллагааны үндэс болно. • Судалгаанд орсон таримлуудаас үр нь боловсорч гүйцээгүй дулаанд дуртай жугар будаа, бог будааны зүйл, сортуудыг дулааны хангамж сайтай баруун, зүүн болон Их нууруудын хотгорын нөхцөлд үрийн зориулалтаар тариалахад тохиромжтой гэж үзэж байна. <p>Энэ төслийн хүрээнд явуулсан үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ сургалт үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх цаашид судалгаа шинжилгээний арга зүйн асуудлыг сайжруулах, хээрийн туршилт судалгааны ажил хийхэд зориулсан тоног төхөөрөмж нийлүүлж байгаа нь сайшаалтай юм.</p> <p>Мал тэжээх сургалтыг явуулж, Англи улсаас импортлосон эрдэс витаминь залгиур болон МААЭШХ-д үйлдвэрлэсэн эрдсийн нэмэгдлээр малыг тэжээснээр малын ашиг шим нэмэгдэх, өвөл хаврын улиралд тарга хүч буурахгүй, шинээр гарсан төл бойжилт сайн байгааг малчид, фермерүүд өөрийн малд туршиж үзсэн нь эрдсийн нэмэгдлийг байнга малдаа худалдан авч өгдөг болсон бөгөөд, ингэснээр малыг төрөл бүрийн эмгэг өвчин тусахаас сэргийлэх нөгөө талаар үйлдвэрлэгч нь</p>

		<p>хэрэглэгчтэй болж эхэлсэн.</p> <p>Төв бүсийн фермер, малчид, аж ахуй нэгжүүдэд дарш болон ногоон тэжээлийн зориулалтаар дээрхи судалгааны үр дүнгээс шалгарсан ногоон масс болон үрийн арвин ургацтай хошуу будаа, арвай, хөх тариа, тритикал, нэг наст райграссын сорт, удмуудын үрийг үржүүлж тариалах бүрэн боломжтой юм.</p> <p>Одоогийн нөхцөлд малчид, фермерүүд нь янз бүрийн чанаргүй өвс, хивэг, будаа(улаан буудай, гурвалжин будаа, рапсны үр), давс, хужир төдийхнөөр малаа тэжээж байна.</p> <p>Дэлхийн дулаарал, бэлчээрийн талхлалт нь малын тоонд бус цөөн ашиг шимтэй малтай болоход малын чанарт анхаарах цаг хэдийн ирснийг харуулж байна. Энэ асуудлыг шийдэхэд уг төслийн үр нөлөө оршино.</p> <p>Төсөлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн малд дарш өгсөн, тарьж буй тэжээлийн ургамлыгн бүтэц, чанарыг сайжруулсан, эрдэс нэмэгдэл тэжээл өгснөөр туршилтын явцад сүүний гарц нэмэгдэж байгаа, тарга хүчээ алдаагүй зэргээс тооцож үзэхэд үр ашигтай болох нь нотлогдож байна.</p> <p>Төслийн хэрэгжилтэд “Хангалттай” гэсэн үнэлгээг өгч байна.</p>
11	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажиллаж байна.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Дарш, тэжээл бэлтгэх, хадгалах үзүүлэх сургалтуудыг явуулах. 2. Орон нутгаас малчид, фермерүүдэд тэжээлийн ургамал тариалах газартай болоход дэмжих, хадлангийн талбайг гэрээгээр эзэмшүүлэх. 3. Тэжээлийн ургамлын үр үржүүлэх бааз, үрийн нөөцтэй болох.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА